

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОРШООЛОГЧДЫН ХОЛБООНЫ ТАЙЛАН.

2015.12.20

1.Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны тухайн жилд гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан:

Энэхүү салбарынбодлого, зорилтыг“Хоршоог хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн хэрэгжилттэй уяалдуулан зохион байгуулж, дараахь арга хэмжээ авч хэрэгжүүллээ. **Үүнд:**

Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэх зорилгоор Аймгийн “Хөдөө аж ахуйн хоршоологчдын VI бага хурал”-ыг Сүхбаатар суманд зохион байгуулж, 17 сумын 70 гаруй хоршоологчид оролцож,хоршооны бодлогын баримт бичиг, холбооны дүрмийн өөрчлөлт, тэргүүлэгч, хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгож, хойшид анхаарах асуудлаар ярилцан ярилцаж цаашдын чиг хандлагаа тогтоосон.



Орон нутгийн хоршоологчдын үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээгдэхүүн, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор ХХААГ-тай хамтран “Сэлэнгэд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг аймгийн төв Сүхбаатар сум, Баруунбүрэн сумын “Амарбаясгалант хийд”, Буриад улсын Зэдийн район, Архангай аймагтзохион байгуулж, 17сумын давхардсан тоогоор 30 хоршоо 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнтэй оролцож, 8,2 сая төгрөгний борлуулалт хийсэн.



“Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас Цагааннуур сумын “Хуурч сүрэг” хоршоонд сүү боловсруулах цехийн үйл ажиллагаа өргөжүүлэхэд 20 сая төгрөг, сум хөгжүүлэх сан болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Мандал сумын 3 хоршоонд 40 сая төгрөгний зээлийг шинээр болон үйл ажиллагааг нь өргөжүүлэхэд олгосон.

“Адра” олон улсын байгууллагатай хамтран “Хоршооны анхан шатны сургалт, хүлэмжийн аж ахуй эрхлэх талаар сургалт”-ыг Сант суманд зохион байгуулж, 4 хоршооны 48 гишүүнийг хамруулсан.

2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан “Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үндэсний чуулган”-д 4 хоршооны төлөөллийг оролцуулав.

Аж үйлдвэрийн яам, МҮХАҮТ-тай хамтран 5 дугаар сарын 13-ны өдөр ажил хэргийн уулзалт зохион байгууллаа. Тодруулбал, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат Монгол Улс, Япон Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэх гэж байгаатай холбогдуулан хамтран ажиллаж буй болон хамтран ажиллах сонирхолтой хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй ажил хэргийн уулзалт хийсэн юм. Үүнд Сант сумын Усан хээр хоршоо оролцсон.

Энэ оны 07 дугаар сарын 13-наас 16-нд Увс аймагт зохион байгуулагдсан “Баянхонгор, Увс, Сэлэнгэ аймгийн хоршоологчдын туршлага судлах уулзалт”-нд Сүхбаатар сумын 4 хоршоог оролцуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 тогтоолоор батлагдсан “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох шинэчилсэн журам”, 2013 оны 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал

олгох журам”-ын 4,7-д заасан хугацаанд онлайн программаар 17 сумын 2 000 гаруй малчны 407 тн ноос, 1 974 малчны 51 192 ш хонины нэхий, 35 491 ш ямааны арьс, 9 253 ш үхрийн шир, 1 197 ш адууны шир нийт 98 136 ш арьс ширний материалыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал хамгаалах санд хүргүүлж, санхүүжилтийг олгох ажлыг ХХААГ-тай хамтран зохион байгуулан ажиллаж байна.

2015 оны 07 дугаар сарын 03-нд Олон Улсын Хоршоологчдын өдрийг аймгийн төв Сүхбаатар суманд тэмдэглэн, энэ үеэр Цагааннуур, Жавхлант, Сүхбаатар сумын 15 хоршооны 30 нэр төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа гаргаж, 3,5 сая төгрөгний бүтээгдэхүүний борлуулалт хийсэн.

Сүхбаатар сумын төвийн хог цэвэрлэх “Цэвэр орчин хоггүй ирээдүй” 1 өдрийн аяныг зохион байгуулж, хоршоодын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний гборлуулах дэлгүүр, Аймгийн Хөдөө Аж ахуйн Хоршоологчдын холбооны байрыг тохижуулан нээж, Сүхбаатар сумын “Өсөх сүрэг” хоршооны дарга Ж.Дулмааг аймгийн Засаг даргын “ЖУУХ БИЧИГ”-ээр, Цагааннуур сумын “Хуурч сүрэг” хоршоо, Жавхлант сумын “Бумбат таван богд” хоршоог Аймгийн Хоршоологчдын холбооны “Өргөмжлөл”-өөр тус тус шагнаж урамшуулсан.



8 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд Булган аймгийн Сайхан суманд болсон Төв хангайн бүсийн Хөдөө аж ахуйн хоршооны үндэсний холбооны зөвлөгөөнд 7 хоршоо хамрагдсан.

Аймгийн Хоршоологчдын холбооны хяналтын зөвлөлийн дарга Сүхбаатар сумын “Үхрийн нүд” хоршооны дарга Д.Цэндсүрэнг “Аймгуудын холбооны хяналтын зөвлөлийн дарга нарын 3 хоногийн сургалт”-нд хамруулсан.

Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөрөөс манай аймагт хэрэгжиж буй “Орон нутгийн цогц

хөгжил төсөл”-ийн хүрээнд явагдсан “Жижиг дунд үйлдвэрийн чадавхижуулах 3 удаагийн сургалтанд Сүхбаатар сумын 5 хоршоог оролцуулсан.



“Аймгийн Хоршоологчдын холбоо, Жижиг дунд үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдын хамтарсан шинэ жил”-ийг 2015 оны 12 дугаар сарын 16-нд Сүхбаатар суманд зохион байгуулж, Жавхлант, Сүхбаатар, Ерөө, Мандал, Цагааннуур сумдын 30 хоршоологчдийг оролцуулж, 2015 оны ажлаа дүгнэж, ажлаараа тэргүүлсэн Жавхлант сумын “Бумбат Таван Богд” хоршоо “Шилдгийн шилдэг өргөмжөл”-өөр, Аймгийн Засаг даргын “ЖУУХ БИЧИГ”-ээр 3 нь жижиг дунд үйлдвэрлэгчдийг шагнасан.



Эдгээр арга хэмжээ авч хэрэгжүүлсэний үр дүнд аймгийн хэмжээнд улсын бүртгэлд бүртгэлтэй **140 хоршоо 2243 гишүүнтэйгээр** үйл ажиллагаа явуулж, энэ онд **40 нэр төрлийн** бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, **70 сая төгрөгний** ашигтай ажиллаж, сүүлийн 5 жилийн байдлаар шинээр хоршоо байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн хоршооны тоо **2014 оныхоос 2 хувиар** нэмэгдсэн.

2. Гишүүддээ үйлчилсэн байдал:

Аймгийн хоршоологчдын бүтээгдэхүүн үйлчилгээ үйл ажиллагаа сурталчилах зорилгоор аймгийн төв Сүхбаатар сум, Баруунбүрэн сумын “Амарбаясгалант хийд”, Буриад улсын Зэдийн район, Архангай аймагт 45 хоршоог оролцуулан үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.

Хоршоодыг эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих зорилгоор 4 хоршоонд 60 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг үйл ажиллагаа өргөжүүлэх, шинээр ажлын байр бий болгоход олгуулсан.

Хоршоологчдын хэрэгцээнд тулгуурласан 7 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 95 хоршооны 300 гишүүнийг хамруулсан.

Үндэсний болон аймгийн холбооноос зохион байгуулж буй ажил, мэдээ мэдээллийг цахим шуудангаар шуурхай хүргэн ажиллаж байна.

Аймгийн хоршоологчдыг дэмжиж урамшуулах зорилгоор аймгийн болон засгийн газрын шагнал, төрийн дээд шагналуудад тодорхойлон дэмжин материалыг нь дээд байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Хоршооны удирдлагуудад аймгийн хууль зүйн хэлтэстэй хамтран хоршооны хуулийн талаар зөвлөгөө семинар өгсөн.

3. Аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны хөрөнгийн ашиглалт, чанарын ахиц, ажиллах чадварын өсөлт:

Аймгийн хэмжээнд улсын бүртгэлд бүртгэлтэй **140 хоршоо 2243 гишүүнтэйгээр** үйл ажиллагаа явуулж, үүнээс аймгийн хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоонд 35 хоршоо гишүүнчлэлийн татвараа бүрэн төлүүлсэн.

Холбооны дансанд энэ жил 985 000 төгрөг төвлөрснөөс 500 000 төгрөг нь үндэсний холбооны гишүүнчлэлийн татварт өгсөн.

Үлдэгдэл 485 000 төгрөгийг “Олон Улсын Хоршоологчдын өдөр”-ийг тэмдэглэх үеэр үзэсгэлэн худалдаа, сургалт зохион байгуулахад зарцуулсан.

Аймгийн Засаг даргын санаачлагаар Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газрын 1 давхарт байр гаргаж өгч, ширээ сандалтай болж, хоршооны талаар гарын авлагаар ханган ажиллах нөхцөл бүрдэж, зөвлөгөө өгч ажиллаж байна.

4. Үүрэг даалгаврын биелэлт:

Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны даргад Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооноос өгсөн үүрэг даалгавар:

“Хөдөө аж ахуйн хоршоологчдын VI бага хурал”-ыг зохион байгуулах./Тухайн жилд гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланд тусгагдсан/

Аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны үйл ажиллагааг тогтмолжуулан идэвхижүүлэх, гишүүнчлэлийн тоо нэмэгдүүлэх

/Холбоонд гишүүн 35 хоршооны 985 000 төгрөг татварыг оруулж, 500 000 төгрөг нь Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны гишүүнчлэлийн татвар өгсөн.

Аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоог байр, тоног төхөөрөмжөөр хангаж, төв болон аймгийн хоршоологчдын холбооноос зохион байгуулж буй ажилд оролцуулах, мэдээллийг шуурхай дамжуулах

Аймгийн Хөдөө Аж ахуйн Хоршоологчдын холбооны байртай болж, шаардлагатай ширээ сандал, гарын авлага материалаар хангаж тохижуулсан.

/Мөн аймгийн холбоо гүйцэтгэх захиралтай болж, үндэсний холбооноос ирж буй мэдээлэл, аймгийн холбооноос зохион байгуулж буй ажлуудын гишүүн хоршоод түргэн шуурхай хүргэж байна./

ТАЙЛАН ГАРГАСАН:

Р.ЭНХТУУЛ /ХХААГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН/

ТАНИЛЦСАН:

С.БҮРЭНБАТ /АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА/